

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ-д:

**ХЭЛЭЛЦСЭН** нь: Хог хаягдлын нормативыг тогтоох аргачлал болон хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тооцох аргачлал батлах тухай

**ШИЙДВЭРЛЭСЭН** нь:

“Хог хаягдлын тухай хуулийн 6.1.3-т заасныг үндэслэн Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тооцох аргачлалыг, 6.1.4-т заасныг үндэслэн хог хаягдлын нормативыг тогтоох аргачлалыг батлахаар тогтов” гэжээ.

Гарын үсэг

## Танилцуулга

### Хог хаягдлын төлөв байдал, үйлчилгээний хураамж, үүрэг, зорилт

Монгол улсын эрчимтэй хөгжил, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Мөрөн гэх зэрэг хүн амын механик өсөлттэй суурингууд, уул уурхайн олборлох үйлдвэр болон барилгын салбарын эрчимтэй хөгжил, хүн амын ахуйн соёлын түвшний доройтол, дэд бүтцийн сул дорой байдал, зах хязгаар нутгийн хүн амын бага нягтшил, орон нутгийн эдийн засгийн чадавхи гэх зэрэг олон хүчин зүйл Монгол улсад хог хаягдалтай холбоотой хурц асуудлыг үүсгэж байна.

Нөгөө талаас хог хаягдал, тэдгээрийн зүгээс орчныг бохирдуулах байдал нь зөвхөн өнөөгийн хүмүүс төдийгүй ирээдүй хойчид уг газар нутагт амьдрах хүмүүсийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах асуудлыг хөнддөг тул хог хаягдлын оновчтой бодлого явуулах хэрэгцээг нөхцөлдүүлж байдаг. Уг бодлогыг хэрэгжүүлэх гол арга, хөшүүргүүдийн нэг нь хог хаягдалтай холбоотой үйлчилгээний хураамжийг оновчтой тогтоох явдал мөн бөгөөд улс орны хувьд нэгдсэн арга зүй ашиглах нь үйлчилгээ үзүүлж, авч байгаа аль аль талын ашиг сонирхолд нийцнэ.

**Хог хаягдлын үйлчилгээний хураамж тооцох шинэ аргачлалаар** хог хаягдлыг бууруулах, түүхий эдийн ашиглалтыг нэмэгдүүлэх, аюултай болон энгийн хог хаягдал, бусад төрлөөр хог хаягдлыг ялган хаядаг тогтолцоог үйлчилгээний хураамжийн бодлогоор дэмжих боломжийг суулгаж өгсөн.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж нь Монгол улсын хувьд орон нутагт бүрт харилцан адилгүй тогтоогдож, тооцох нэгдсэн арга зүйд суурилагагүй байгаа нь зарим тохиолдолд үйлчлүүлэгч хохирох, дийлэнх тохиолдолд үйл ажиллагаа явуулж буй компани нь үйлчилгээнийхээ чанарыг сайжруулах, техник тоног төхөөрөмжийнхөө парк шинэчлэлтийг хийх чадамжгүй байхад нөлөөлж байна. Энэ байдал нь улсын болон орон нутгийн төсвөөс багагүй хэмжээний татаасыг хог хаягдлын асуудлыг шийдвэрлэхэд гаргуулж байна. Гэсэн хэдий ч хог хаягдлаар бохирлогдсон талбай улам ихсэж байгаа нь хог хаягдлын хураамжийн үнийн бодлого, арга зүйд өөрчлөлт оруулахад хүргэж байна.

Уг боловсруулсан аргачлалаар нэг талаас үйлчилгээний хураамж тооцох нэгдсэн бодлогын үндэслэлийг гаргаж тавьж байгаа бөгөөд нөгөө талаас тухайн орон нутгийн онцлогт тохируулан хувирган ашиглах бололцоог олгож байгаа юм.

**Хог хаягдлын норматив тогтоох аргачлал нь** “Хог хаягдлын тухай хуулийн” хэрэгжилтийг холбогдох төрийн байгууллагуудаар хангуулах, холбогдох төрийн байгууллагуудаар хангуулах, ЗР буюу хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжихэд анхан шатны түвшинд хангах суурь нөхцлийг бүрдүүлэх боломжийг суулгаж өгсөн.

Өмнөх аргачлал нь хот суурин газрын ахуйн гаралтай хог хаягдалд норматив тогтооход чиглэгдсэн байсан бол шинэ аргачлалаар үйлдвэрлэлийн гаралтай болон салбарын хог хаягдлын норматив тогтооход ашиглагдах боломжийг нэмж суулгаж өгсөн.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны ... дугаар  
сарын ... –ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Хог хаягдлын үйлчилгээний хураамж тооцох,  
норматив тогтоох аргачлал батлах тухай

Хог хаягдлын тухай хуулийн 6.1.3; 6.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хог хаягдлын нормативыг тогтоох аргачлалыг 1 дүгээр хавсралтаар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тооцох аргачлалыг 2 дугаар хавсралтын ёсоор баталсугай
2. Хог хаягдлын нормативыг тогтоох, үйлчилгээний хураамжийг тооцох аргачлалыг мөрдөж ажиллахыг холбогдох төрийн байгууллагуудад үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Хог хаягдлын норматив тогтоох, төлбөр тооцох аргачлал батлах тухай” Засгийн газрын 2007 оны 17 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Ч.САЙХАНБИЛЭГ

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН САЙД

Д.ОЮУНХОРОЛ

## ХОГ ХАЯГДЛЫН НОРМАТИВ ТОГТООХ АРГАЧЛАЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү аргачлалыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд харьяа салбарын; аймаг, нийслэлийн засаг дарга нар харьяа засаг захиргааны нэгжид хог хаягдлын норматив тогтооход ашиглана.
- 1.2. Аргачлалаар Монгол улсын хэмжээнд хог хаягдлын норматив тооцох болон хаягдлын дээд хязгаар үзүүлэлт боловсруулахад ашиглах нэгдсэн аргагүйг тогтооно.
- 1.3. Энэхүү аргачлалыг ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай хог хаягдлын норматив тогтооход дагаж мөрдөнө.
- 1.4. Цацраг идэвхт хог хаягдалд энэхүү аргачлал хамаарахгүй.
- 1.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд өөрийн явуулж байгаа үйл ажиллагаатай холбоотой хог хаягдлын норматив тогтооход уг аргачлалыг ашиглаж болно.
- 1.6. Аргачлал нь дараах зорилтыг хангана:
  - Хог хаягдлын жилд үүсэх хэмжээ, хязгаарыг тогтоох(кг/өдөр, тонн/жил )
  - Дахин ашиглагдах болон саармагжуулах хог хаягдлын хэмжээг тогтоох
  - Нэгж хог хаягдлын норматив буюу нэг хүн, нэг өрх, нэгж үйлчилгээний талбай, нэгж хүчин чадал, нэгж бүтээгдэхүүнд ногдох хог хаягдлын хэмжээг тогтоох
  - Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг ялгавартай тогтоох суурь нөхцлийг бүрэлдүүлэх
- 1.7. Хог хаягдлын нормативыг 4 жил тутамд, шаардлагатай тохиолдолд түүнээс өмнө шинэчлэн тогтооно.
- 1.8. Хог хаягдлын норматив тогтооход дараах зарчмыг баримтлана:
  - Байгалийн нөөц, түүхий эд, эрчим хүчний нөөцийг оновчтой, хэмнэлттэй ашиглах
  - Орчны бохирдол, хог хаягдлыг бууруулах
  - Хог хаягдлыг дахин ашиглах болон хог хаягдлыг ялган хаях тогтолцоог бүрдүүлэх
  - Орон нутаг болон үндэсний хэмжээнд үүсч байгаа хог хаягдлын бүтэц, хэмжээг бодиттой илэрхийлэх статистик үзүүлэлт бүрдүүлэх
- 1.9. Хог хаягдлын жилд үүсэх хэмжээг тооцохдоо “тн/жил” гэсэн нэгжээр илэрхийлэх бөгөөд тухайн хог хаягдлын онцлогоос нь хамаарч нормативыг “м<sup>3</sup>/ өдөр”, “ширхэг/өдөр” гэсэн нэгжээр тогтоож болно.

Хэрэв хог хаягдлын нэгж нормативыг “м<sup>3</sup>/ өдөр”-өөр тогтоовол тухайн хог хаягдлын нягт буюу 1 метр куб хог хаягдлын хувийн жинг ашиглан хүндийн жинд хувиргах замаар жилд үүсэх хэмжээг тооцно.

Хэрэв хог хаягдлын нэгж нормативыг “ширхэг/өдөр” -өөр тогтоовол ширхэгээр илэрхийлэгдэж байгаа тухайн төрлийн хог хаягдлын дундаж жинг үржих аргаар хүндийн жинд шилжүүлэх замаар жилд үүсэх хэмжээг тооцно.
- 1.10. Овор хэмжээ, эзэлхүүн эхтэй хог хаягдал тээвэрлэхэд үүсэх зардлыг бодиттой тооцох боломж бүрдүүлэх болон хог хаягдлын овор хэмжээг бууруулах менежментийг эх үүсвэр дээр нь авч хэрэгжүүлэх зохицуулалт бий болгох зорилгоор нэгж хог хаягдлын нормативыг эзэлхүүнээр тогтоож болно.
- 1.11. Нэгж хог хаягдлын норматив нь хог хаягдлын улсын тоо бүртгэл, хог хаягдлын эх үүсвэрийн тайланг үнэн бодиттой хөтлөх суурь нөхцөл, хог хаягдлын мэдээллийн сангийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь байна.

## **Хоёр. Нэгж хог хаягдлын норматив тогтоох аргачлалын төрөл**

### **2.1. Нэгж хог хаягдлын нормативын төрөл**

Нэгж хог хаягдлын норматив тогтоох аргачлалыг зорилгоос нь хамрааруулж хоёр төрөлд хуваана:

- 1. Ахуйн болон үйлчилгээний.** Төв суурин газар болон нийтийн эзэмшлийн зам, талбайд үүсч байгаа тодорхой нэр төрлийн хог хаягдлын дундаж хэмжээг оновчтой байх нэгж үзүүлэлтэд нь харгалзуулан тогтооход ихэвчлэн ашиглах аргачлал юм. Хүйтний, дулааны эсвэл өвөл, хавар, намар, зун гэж хог хаягдлын бүтцийн онцлог, гарах хэмжээний ялгавартай байдалд үндэслэн нормативыг улиралд харгалзуулан тогтоож болно.
- 2. Үйлдвэрлэлийн.** Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад үүсэх тухайн төрлийн хог хаягдлын дундаж хэмжээ, гарцыг тогтоох аргачлал гэж ойлгоно.

### **2.2. Ахуйн болон үйлчилгээний нэгж хог хаягдлын нормативыг тогтоох аргачлал**

Энэхүү аргачлалаар төв суурин болон хүмүүсийн төвлөрөл бий болсон газарт бодиттой явагдаж байгаа үйл ажиллагаанд зураг авалт хийж, тухайн хугацаанд үүссэн хог хаягдлын хүндийн жин, эзэлхүүний дундаж хэмжээг хэмжиж, тухайн хаягдлын илэрхийлэл болж чадах нэгж үзүүлэлтэд харгалзуулах судалгаа явуулж гаргана.

Дараах үзүүлэлтээр улиралд харгалзуулах байдлаар нэгж хог хаягдлын нормативыг тогтооно:

2.2.1. Гэр хорооллын айл өрхөөс гарах үнсийг нэг өдөрт түлэх түлшний дундаж хэрэглээ болон зуухны шаталтын зэрэгт харгалзуулан, ахуйн хаягдлыг нь өрхийн нэг гишүүнд ногдох хэмжээгээр тооцноор;

2.2.2. Төв, суурин газар дахь мал бүхий иргэдийн мал аж ахуйгаас гарах ялгадсын хэмжээг малын төрлөөр, нэгж толгойд тооцноор;

2.2.3. Иргэдийн ахуйн хэрэглээнээс гарсан хаягдал цаас, мод, шилэн болон хуванцар сав, баглаа боодлын чанартай эд зүйлийн хэмжээг хүндийн жингээр;

2.2.4. Нийтийн орон сууцанд амьдардаг айл өрхөөс гарах хог хаягдлыг өрхийн нэг гишүүнд ногдох хэмжээгээр тооцноор;

2.2.5. Үйлдвэрийн газрын хог хаягдлыг тогтоосон хүчин чадлынх нь ашиглалтаар тооцож нэгж бүтээгдэхүүнд ногдох үндсэн болон туслах материал, түүхий эдийн орцтой уялдуулсан хэмжээгээр; (Үйлдвэрлэлийн нэгж хог хаягдлын норматив тогтоох хэсэгт илүү дэлгэрэнгүй дурдагдсан тул холбогдох хэсгээс тохирох аргачлалыг авч ашиглах)

2.2.6. Энэ журмын 2.2.5-д зааснаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн хог хаягдлыг нэгж бүтээгдэхүүнд нь ногдох хэмжээгээр тооцноор; (Үйлдвэрлэлийн нэгж хог хаягдлын норматив тогтоох хэсэгт илүү дэлгэрэнгүй дурдагдсан тул холбогдох хэсгээс тохирох аргачлалыг авч ашиглах)

- 2.2.7. Худалдааны газар, эмийн сан, дэлгүүрийн хог хаягдлыг түүний ашигтай талбайн нэгж тутамд ногдох хэмжээгээр тооцсон хэмжээ, үйлчилгээний төрөл ангиллаар;
- 2.2.8. Сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, амралт сувиллын байгууллын хог хаягдлыг нэг сурагч, хүүхэд болон үйлчилгээний ор тутамд тооцсоноор;
- 2.2.9. Нийтийн хоол, гуанз, рестораны хог хаягдлыг суудлын тоог ажлын цагаар үржүүлснээр буюу суудал/цагт ногдуулан тооцсон хэмжээгээр;
- 2.2.10. Нийтийн үзвэр, үйлчилгээний газар, урлагийн байгууллагын хог хаягдлыг ажиллах цагийг суудлын тоогоор үржүүлснээр буюу суудал/цагт ногдуулан тооцсон хэмжээгээр;
- 2.2.11. Авто гарааж, засвар үйлчилгээ, машин угаалгын газрын хог хаягдлыг хүчин чадлын нэгжид ногдох хэмжээгээр тооцсоноор;
- 2.2.12. Барилга угсралт, засварын ажлын хог хаягдлыг тухайн барилгыг барихад зориулсан ашигтай талбайн нэгжид ногдох хэмжээгээр тооцсоноор; (Үйлвэрлэлийн нэгж хог хаягдлыг тогтоох туршилтын болон статистик аргыг ашиглах боломжтой)
- 2.2.13. Албан байгууллагын хог хаягдлыг нэгж орон тоонд ногдох хэмжээгээр тооцсоноор;
- 2.2.14. Шатахуун түгээх станцын хог хаягдлыг үйлчилгээний талбайн нэгжид ногдох хэмжээгээр тооцсоноор;
- 2.2.15. Гудамж зам, нийтийн эзэмшлийн талбай, улсын болон орон нутгийн зам дагуух зорчигдын амрах талбайн хог хаягдлыг нэг хавтгай дөрвөлжин метр талбайд ногдох хэмжээгээр тооцсоноор. /Суурингийн төв гудамж, гэр хороолол, захын хороололын гудамж, нийтийн эзэмшлийн болон зам дагуу талбай зэргээр ангилан ялгавартай тооцно./
- 2.2.16. Аялал жуулчлалын баазууд, дэн буудлыг үйлчилгээний ор тутамд тооцсоноор
- 2.2.17. Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал болох ашигласан тос, тосолгооны материал, хөргөх шингэн, шүүлтүүрийг цилинтрийн нэгж багтаамжид ногдох хэмжээгээр тооцсоноор
- 2.2.18. Хатуу хучилттай зам тавих, засварлах ажлын хаягдлыг хатуу хучилттай талбайн нэгжид ногдох хэмжээгээр тооцсоноор
- 2.2.19. Аюултай хог хаягдлын хэмжээг дээр дурдсан ангилал бүрийг тооцсон нэгж үзүүлэлтийг ашиглан ангилал бүрээр тусад нь тогтооно. Тухайн үйл ажиллагааны чиглэлээс гарах аюултай хог хаягдлын норматив тогтооход “Аюултай хог хаягдлын жагсаалт”-ыг ашиглана.

### **2.3. Үйлдвэрлэлийн нэгж хог хаягдлын норматив тогтоох аргачлалууд**

#### **2.3.1. Техникийн баримт бичиг дэх ашиглалтын хугацааг ашиглах арга.**

Техникийн баримт бичигт ашиглалтын хугацаа нь хязгаарлагдаж тогтоогдсон материал, эдэлхүүний биет болон моралын элэгдлийн үр дүнгээр тооцоологдох жилийн хог хаягдлын нормативын тооцохдоо урьдчилан хог хаягдлын нормативыг тооцохгүйгээр аргачлалын хавсралтын (2.3.1) томъёог ашиглана.

### 2.3.2. **Материал - түүхий эдийн баланс ашиглан норматив тогтоох аргачлал**

Материал-түүхий эдийн баланс нь үйлдвэрлэлийн хаягдлын нормыг тогтоох суурь нь болдог. Олон нэр төрлийн түүхий эд ашигладаг, эсвэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрлэлийн хог хаягдлыг нормативыг тогтооход хэрэглэнэ.

Материал-түүхий эдийн балансын тооцоонд дараах үзүүлэлтүүдийг хэрэглэнэ. Үүнд:

- нэгж хугацаанд ашиглах материал, түүхий эдийн тоо хэмжээ;
- бүтээгдэхүүн болж буй материал, түүхий эдийн тоо хэмжээ;
- үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ;
- хэвийн хорогдлын нормууд;
- агаарт хаягдаж байгаа болон урсаж гарч байгаа бохир ус, бодисын тоо хэмжээ;

Тооцоонд ашиглах анхан шатны үзүүлэлтэд технологийн карт, технологийн регламент, материал, түүхий эдийн ашиглалтын үзүүлэлтүүд, материал, түүхий эдийн зарцуулалтын бүртгэлийн материалууд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, агаар мандал, усанд хаягдаж буй орчныг бохирдуулагч бодисын эх үүсвэрийн бүртгэлийн үр дүн, хог хаягдал үүсэх эх үүсвэр, хог хаягдлын хяналтын үзүүлэлтүүд хамаарна.

Тооцоонд ашиглах үзүүлэлтүүдийн тоо хэмжээнээс хамааран хог хаягдлын нормативыг хэд хэдэн хувилбараар тооцож болно.

1. Хэрэв нэгж хугацаанд үйлдвэрлэх бүтээгдэхүүн, хог хаягдлын тоо хэмжээний үзүүлэлт, өгөгдлүүд мэдэгдэж байгаа тохиолдолд хог хаягдлын нормативыг аргачлалын хавсралтын (2.3.2.1) томъёог ашиглана. (Цаашид хог хаягдлын нормативыг тогтоох аргачлалын хавсралтыг – аргачлалын хавсралт эсвэл хавсралт гэнэ)
2. Хэрэв нэгж хугацаанд үйлдвэрлэх бүтээгдэхүүн, хог хаягдлын тоо хэмжээний үзүүлэлт, өгөгдлүүд байхгүй боловч бүтээгдэхүүн бий болоход шаардагдах материал, түүхий эдийн тоо, хэмжээ болон нэгж хугацаанд бий болох бүх хаягдлын нийлбэр мэдэгдэж байгаа тохиолдолд хог хаягдлын нормативыг аргачлалын хавсралтын (2.3.2.2), (2.3.2.3) томъёогоор тооцно.
3. Бусад тохиолдолд хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлээд нэг төрлийн хаягдлыг бий болгож буй үед нэгж бүтээгдэхүүнд ноогдох хог хаягдлын хувийн жингийн хэмжээг харуулж байдаг хог хаягдлын бүлэг (групп) нормативыг ашиглана. Хог хаягдлын бүлэг (групп) нормативыг тодорхойлохын тулд эхлээд хог хаягдлын нийлбэр тоо хэмжээг аргачлалын хавсралтын (2.3.2.4) томъёогоор, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэгжид ноогдох бүлэг хог хаягдлын жигнэсэн дундаж нормативыг аргачлалын хавсралтын (2.3.2.5) томъёогоор тус тус тодорхойлно. Дээр дурдсан хог хаягдлын нормативын тооцоонуудыг гаргахад шаардлагатай анхан шатны өгөгдлүүд байхгүй бол газар дээр нь биет байдлаар хэмжилт явуулна.

### 2.3.3. **Аналитик –тооцооны аргачлал**

Энэ арга нь хог хаягдал бий болгох тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зохион бүтээлтийн болон технологийн баримт бичиг (технологийн карт, регламент, ажлын зураг) -тай тохиолдолд хэрэглэгдэнэ.

Тооцоо хийхдээ эдгээр техникийн баримт бичиг болон тогтоогдсон материал, түүхий эдийн зарцуулалтын нормыг баримтлан нэгж бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зарцуулах түүхий эд, материалын нормоос зайлшгүй эргүүлж ашиглах боломжгүй хаягдлыг тооцсон цэвэр (ашигтай) зарцуулалтыг хасах замаар тухайн бүтээгдэхүүний хаягдлын нормативыг аргачлалын хавсралтын (2.3.3.1) томъёог эсвэл (2.3.3.2) томъёогоор тодорхойлно.

Хог хаягдлын нормативыг хувиар илэрхийлэх болон хоёр дахь түүхий эдийн гаралтын коэффициентыг аргачлалын хавсралтын (2.3.3.3) томъёогоор тодорхойлно. Эдгээр гурван томъёогоор төрөл бүрийн хог хаягдлын нормативыг тодорхойлох боломжтой.

Нийт үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэгжид ноогдох жигнэсэн дундаж бүлэг (групп) хог хаягдлын нормативыг аргачлалын хавсралтын (2.3.3.4) томъёогоор тодорхойлно.

#### **2.3.4. Хог хаягдлын норматив тогтоох туршилтын аргачлал**

Материал, түүхий эдийн бүтцийн элементүүдийн өөрчлөлтийн тодорхойлсон хүрээ бүхий технологийн процесст (ган цувимал, хими, хүнс, микробиологийн болон бусад аж үйлдвэрүүд), түүнчлэн хөдөлмөр зарцуулалт ихтэй аналитик тооцооны үед хог хаягдлын нормативыг үйлдвэрлэлийн нөхцөлд туршилтын хэмжилтүүд хийх замаар тодорхойлдог туршилтын аргыг хэрэглэнэ. Эхний шатанд материал түүхий эдийн нэгж жингээс гарган авч байгаа ашигтай бүтээгдэхүүний жин (масс)-гийн туршилтын хэмжилтүүдэд статистик боловсруулалт хийсний үндсэн дээр нэгж түүхий эдэд ноогдох ашигтай бүтээгдэхүүний хэмжээг илэрхийлж байдаг үзүүлэлтийг хувь (%) -иар ( $C_{nn}$ ) тодорхойлно.

Энэхүү үзүүлэлтийн утга болон ашигтай бүтээгдэхүүн ( $M_{nn}$ )-ий түүхий эдээс гаргаж авсан жингийн өгөгдлүүдээс хамааруулан хаягдлын жин ( $V_0$ )-г хавсралтын (2.3.4.1) томъёогоор, нэгж бүтээгдэхүүнд ногдох хог хаягдлын норматив ( $H_0^{11}$ )-ыг (2.3.4.2) томъёогоор тус тус тодорхойлно.

Бүтээгдэхүүнийг туршилтын журмаар үйлдвэрлэх үед хог хаягдлын нормативыг тодорхойлохдоо үйлдвэрлэлийн явцад гарах хаягдлын жингийн хэмжилт, мөн тухайн төрлийн бүтээгдэхүүний дундаж үзүүлэлтүүдийг тодорхойлсны үндсэн дээр туршилтын аргаар тодорхойлно.

#### **2.3.5. Бодит гарсан хог хаягдлын хэмжээг үндэслэн хог хаягдлын норматив тооцох статистик аргачлал**

Хог хаягдлын нормативыг тооцох энэхүү арга нь жилд гарсан (3-аас доошгүй жил) хог хаягдлын суурь мэдээлэл, өгөгдөлд статистик боловсруулалт хийсний үндсэн дээр хэрэглэгдэнэ. Хог хаягдлын нормативын тооцоонд зориулсан анхны өгөгдөл болох түүхий эд, бүтээгдэхүүн, нормативыг тооцсон тооцооны үр дүнг хүснэгтийн хэлбэрт оруулна. Энэ үед тайлант болон он бүрээр хог хаягдлын нэгж тоо хэмжээ, хувийн жинг тодорхойлно. Хог хаягдлын нормативыг дараах томъёогоор тодорхойлно. Хог хаягдлын хувийн жингийн тоо хэмжээг тодорхойлохдоо үүссэн хог хаягдлын тоо хэмжээг ашигласан түүхий эдийн тоо хэмжээнд харьцуулах эсвэл нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнд харьцуулж тус тус тодорхойлно. Хавсралтын (2.3.5) томъёог ашиглана.

Хог хаягдлын нормативыг дурын тооцооны нэгж тухайлбал: зай, талбай, хүн, бусад үзүүлэлтээр тодорхойлж болно.

Энэ арга нь тайлант онуудын (3 жилийн) суурь тайлан мэдээний өгөгдлүүдэд статистик боловсруулалт хийсний үндсэн дээр хог хаягдлын нормативыг тодорхойлоход хэрэглэгдэх бөгөөд хог хаягдлын нормативыг тогтоохдоо үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний материал зарцуулалтыг бууруулахаар төлөвлөсөн техник-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулна.

### **Гурав. Хог хаягдлын норматив тогтоох**

- 3.1. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хог хаягдлын норматив тогтоох санал боловсруулах ажлын хэсгийг сум, дүүргийн Засаг дарга, иргэд, үйлдвэр, худалдаа, мэргэжлийн хяналт, статистик, стандартчилал, хэмжил зүй, эрүүл мэнд, татвар-санхүү төсөв, байгаль орчны асуудал хариуцсан нэгжийн төлөөлөл бүхий 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулна.



- 3.2. Ажлын хэсэг нь зураг авалт, хэмжилт, бүртгэл хийх судалгааны баг ажлуулж болно.
- 3.3. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид ажлын хэсгээс боловсруулсан хог хаягдлын норматив тогтоох тухай саналыг баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын удирдлагад танилцуулан санал авч, бусад төв, суурин газар, аймаг, нийслэлд мөрдөж байгаа нормативтай жишиж үзэх ажлыг зохион байгуулна.
- 3.4. Энэ журмын 2.2-т хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын хэмжээг түүний үйл ажиллагааг нь илэрхийлэх боломжтой үндсэн нэгжтэй дүйцүүлэн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.
- 3.5. Үйлдвэрлэлийн нэгж хог хаягдлын нормативыг тооцоходоо энэ журмын 2.3-т тусгасан аргачлалын аль тохирохыг авч ашиглана
- 3.6. Салбарын хог хаягдлын норматив тогтооход салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах зарчмыг баримтална.
  1. Салбарын үйлдвэр, аж ахуйн газруудад зориулан хог хаягдлын нормативын нэг бүрчилсэн (бие даасан) утгуудыг дундчилах;
  2. Тодорхой хугацааны (суурь) тайлангийн үзүүлэлт, мэдээнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр нэгж нормативын дундаж үзүүлэлтийг тооцох, дараа онд эсвэл төлөвлөж буй хугацаанд нэгж норматив боловсруулахад шаардагдах хүчин зүйлүүдийг (туршилтаар) тогтоож гаргах, төлөвлөж буй хугацаанд тэдгээрийн нөлөөллийг тодорхойлох;
- 3.7. Ашиглалтын явцад орчны бохирдол их хэмжээгээр бий болгодог бараа бүтээгдэхүүний хэрэглээг хязгаарлах, сав баглаа боодол болон хог хаягдлыг дахин ашиглахад нөлөөлөх үзүүлэлтийг хог хаягдлын норматив тогтооход ашиглаж болно.
- 3.8. Хог хаягдлын норматив батлах тухай асуудал хэлэлцэхдээ иргэд болон хог хаягдал зайлуулах, түүнчлэн хог хаягдал ихээр гаргадаг аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийг оролцуулан саналыг нь сонсож болно.
- 3.9. Тухайн нутаг дэвсгэрт шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн онцлогтой уялдуулан хог хаягдлын нормативыг тухай бүр шинэчилж болно.

-----o0o-----

**Хог хаягдлын норматив тогтоох аргачлалд ашиглагдах томъёо, илэрхийлэл, үзүүлэлтүүд**

**2.3.1. Техникийн баримт бичиг дэх ашиглалтын хугацаар нормативыг тооцоход ашиглагдах томъёонууд:**

Томъёо:  $G_{H_0} = M_i / T$  (2.3.2.1) Үүнд:

$M_i$  – “хог хаягдал”-ын байдалд тооцогдох материал эдэлхүүний жин;

$T$  – материал, эдэлхүүний ашиглалтын хугацаа

**2.3.2. Материал - түүхий эдийн баланс ашиглан норматив тогтоох аргачлалд ашиглагдах томъёонууд:**

Томъёо:  $H_0 = O / q$  (2.3.2.1) Үүнд:

$H_0$  – хог хаягдлын норматив, тн/ нэгж . бүтээгдэхүүн ;

$O$  – нэгж хугацаанд бий болох хог хаягдлын тоо хэмжээ , тн ;

$q$  – нэгж хугацаанд үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ ;

Томъёо:  $\sum O = \sum N - \sum P - \sum H_n - \sum B - \sum C$  (2.3.2.2) Үүнд:

$\sum O$  - нэгж хугацаанд гарах бүх хаягдлын нийлбэр, тн ;

$\sum N$  – нэгж хугацаанд үйлдвэрлэлд орж буй материал, түүхий эдийн нийлбэр тоо хэмжээ , тн ;

$\sum P$  – нэгж хугацаанд үйлдвэрлэлийн явцад бүтээгдэхүүнд орсон буй материал, түүхий эдийн нийлбэр тоо хэмжээ , тн ;

$\sum H_n$  - нэгж хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн процесст зайлшгүй гарч буй буцааж /эргүүлж/ ашиглахгүй хаягдал материал, түүхий эдийн нийлбэр тоо хэмжээ , тн ;

$\sum B$  - нэгж хугацаанд агаар мандалд цацагдаж байгаа хаягдал дах бохирдуулагч бодисын нийлбэр тоо хэмжээ, тн ;

$\sum C$  – нэгж хугацаанд гарах хаягдлын бүтэц дэх бохирдуулагч бодисын тоо хэмжээ, тн ;

Томъёо:  $H_0 = \sum O / q$  (2.3.2.3)

Хэрэв бүтээгдэхүүн бий болгож байгаа түүхий эд, материалын тоо хэмжээ байхгүй боловч нэгж хугацаанд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ мэдэгдэж байвал томъёо (2.3.2.2) –д тусгагдсан  $\sum P$  –ийг нэгж хугацаанд үйлдвэрлэх бүтээгдэхүүний нийлбэр тоо хэмжээгээр (тн-оор) хэмжигдэх  $\sum q$  – ээр сольж тооцно.

Томъёо:  $CO_{отх} = \sum_{i=1}^m H_i \times q_i$  (2.3.2.4) Үүнд :

$CO_{отход}$  - хог хаягдлын нийт нийлбэр тоо хэмжээ, тн ;

$H_i$  - тухайн нэг төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн процесст бий болох хог хаягдлын норматив , тн ;

$q_i - i$  - төрлийн / тухайн нэг төрөл / бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ ,

$i$  - үйлдвэрлэж буй тухайн төрлийн бүтээгдэхүүний индекс /  $i = 1, 2, 3, 4 \dots m$  / ;

$$\text{Томъёо: } H_{\text{от.гр}} = CO / \sum_{i=1}^m q_i \quad (2.3.2.5)$$

### 2.3.3. Аналитик –тооцооны аргачлалд ашиглагдах томъёонууд:

$$\text{Томъёо: } H_0 = N - P_n - H \quad (2.3.3.1) \text{ Үүнд:}$$

$N$  - нэгж бүтээгдэхүүнд зарцуулах түүхий эд / материал / - ийн зарцуулалтын норм , тн ;

$P_n$  - үйлдвэрлэлийн процесс / ажил /- ийг явуулахад зайлшгүй шаардлагатай түүхий эд, материалын зарцуулалт , тн ;

$H$  - үйлдвэрлэлийн процесст зайлшгүй гарах эргүүлж ашиглах боломжгүй хаягдал, тн:

$$\text{Томъёо: } H_0 = N_n(1 - K_n) - P \quad (2.3.3.2) \text{ Үүнд:}$$

$K_n = H_n/N$  – материал түүхий эдийн зайлшгүй гарах хаягдлын коэффициент ;

$$\text{Томъёо: } H_0^1 = (1 - K_{\text{исп.}} - K_n) \times 100\% \quad (2.3.3.3) \text{ Үүнд:}$$

$(K_{\text{исп.}} = P/N)$  –бүтээгдэхүүний үйлдвэрлэл дэх материал, түүхий эдийн ашиглалтын коэффициент

$$\text{Томъёо: } H_{0 \text{ групп}} = \frac{\sum_{i=1}^m (N_i \times q_i) - \sum_{i=1}^m (P_i + H_{ni}) \times q_i}{\sum_{i=1}^m q_i} \quad (2.3.3.4) \text{ Үүнд:}$$

$q_i$  – тухай нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ ;

$i$  – үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрлийн индекс ( $i=1, 2, \dots, m$ ) ;

### 2.3.4. Хог хаягдлын нормативыг тогтоох туршилтын аргад ашиглах томъёонууд

$$\text{Томъёо: } V_0 = M_{nn} \times \frac{100\% - C}{C} \quad (2.3.4.1) \text{ Үүнд:}$$

$V_0$ - хаягдлын жин

$C_{nn}$ , % -нэгж түүхий эдэд ноогдох ашигтай бүтээгдэхүүний хувь

$M_{nn}$ - түүхий эдээс гаргаж авсан ашигтай бүтээгдэхүүний жин

$$\text{Томъёо: } H_0^{11} = \frac{V_0}{Q_{\text{пр.}}} \quad (2.3.4.2) \text{ Үүнд:}$$

$(H_0^{11})$  - нэгж бүтээгдэхүүнд ноогдох хаягдлын норматив

$Q_{\text{пр.}}$  – үйлдвэрлэлийн явцад хаягдал нь гардаг бүтээгдэхүүний тоо хэмжээ ;

### 2.3.5. Бодит гарсан хаягдлын хэмжээг үндэслэн хог хаягдлын норматив тооцоох статистик аргачлалд ашиглагдах томъёо

$$\text{Томъёо: } H_0 = \sum_{i=1}^m H_{oi} / T \quad (2.3.5) \text{ Үүнд:}$$

$H_{oi}$  –  $i$  жилд гарсан хаягдлын хувийн жингийн тоо хэмжээ ;

$T$  – тооцоонд авч үзэж байгаа жилийн тоо ;

## ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ ТОГТООХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

### 1.1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн тухай ойлголт.

Хог хаягдлын менежментийн бодлогыг тухайн засаг захиргааны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх эдийн засгийн үндсэн хөшүүрэг, арга хэрэгсэл нь хог хаягдлын үйлчилгээний хураамж болно.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хог хаягдал үүсгэгч буюу эх үүсвэр бүр төлөх үүрэгтэй<sup>1</sup>.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж гэдэг нь тухайн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааны зардлыг шингээсэн зөвхөн үйлчилгээний төлбөр биш бөгөөд уг хураамжид хог хаягдлыг бууруулах ажлыг дэмжих, урамшуулах, мэдээлэл, сургалт, суртчилгаанд зарцуулах хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зардлыг шингээсэн байна.<sup>2</sup>

1.2. Аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг дарга нь Хог хаягдлын тухай хуулийн 8.1.2-т заасны дагуу энэхүү аргачлалыг ашиглан нутаг дэвсгэртээ мөрдөгдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтооно.

1.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тухайн нутаг дэвсгэр мөрдөхөөр батлагдсан хог хаягдлын норматив, хог хаягдлын менежментийн бодлого, хөтөлбөрт үндэслэн тогтооно.

1.4. Энэхүү аргачлалын хүрээнд тухайн орон нутагт үйлчилгээний хураамжаас чөлөөлөгдөх иргэн, хуулийн этгээдүүд болон түүний үндэслэл, дүйцүүлэх төлбөрийн хэлбэр, хэмжээ зэргийг тусган ашиглаж болно.

## Хоёр. Хог хаягдлын үйлчилгээний хураамж тогтоох

### 2.1. Хог хаягдлын үйлчилгээний хураамж тогтооход баримтлах зарчим

1. Бохиртуулагч нь төлдөг байх
2. Хураамж нь орон нутагт үүссэн хог хаягдлыг цогцоор нь шийдвэрлэх бодлогод суурилсан байх
3. Хураамж нь өрхийн амьдрал, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн үйл ажиллагааг доголдуулах хэмжээний дарамт учруулахгүй байх
4. Хураамж нь тухайн төрлийн хаягдлыг хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хор аюулгүй устгаж, зайлуулахад хүрэлцэхүйц байх

2.2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн бүрэлдэхүүн хэсэг. Хог хаягдлын үйлчилгээний хураамж нь суурь болон нэмэлт зардал гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ:

2.2.1 Хог хаягдлын үйлчилгээний суурь зардал. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгахтай холбоотой гарах нийт зардлыг үндэслэн тогтооно. Үүнд:

1. Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардал
2. Хог хаягдлыг устгах үйл ажиллагааны зардал
3. Хог хаягдлыг хөрсөөр дарж булах үйл ажиллагааны зардал
4. Аюултай хог хаягдлыг саармагжуулах үйл ажиллагааны зардал
5. Бусад холбогдох үйл ажиллагааны зардал

Суурь хураамжийг дээрх зардал тус бүрээр нарийвчлан тооцож болохоос гадна эх үүсвэрийн төрлөөс (*айл өрх, байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгч эсвэл энгийн аюултай гэх мэт*) хамааран

<sup>1</sup> Хог хаягдлын тухай хуулийн 19.1.2: 20.1 заалт

<sup>2</sup> Хог хаягдлын тухай хуулийн 20.3 дугаар заалт

дээрх зардал бүрийг тооцолгүйгээр шаардлагатай зарим зардлуудыг түүвэрлэн сонгон тогтоож болно.

### 2.2.2. Хог хаягдлын үйчилгээний хураамжид нэмж тооцох зардлууд

Хог хаягдлын тухай хуулийн 20.3-т заасны дагуу хог хаягдлыг бууруулах менежментийг хэрэгжүүлэхэд шаардагдах гурван төрлийн зардлыг үйлчилгээний хураамжид шингээж тогтооно. Үүнд:

- Хог хаягдлыг бууруулах үйл ажиллагааг дэмжих зардал
- Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаа эрхэлсэн болон хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг суртчилах, урамшуулах зардал
- Хог хаягдалтай холбоотой мэдээлэл, сургалт, суртчилгааны зардал

### 2.3. Хог хаягдлын төлбөрийг тогтооход харгалзан үзэх хүчин зүйлүүд

- Хог хаягдлын эх үүсвэрээс тэдгээрийг тээвэрлэх төвлөрсөн цэгийн алслагдсан байдал;
- Хог хаягдал ачих, буулгах арга ажиллагааны механикжсан байдал;
- Хог хаягдлын эзэлхүүн -овор хэмжээ эсвэл хүндийн жин
- Тээврийн хэрэгслийн даац ашиглалтын үзүүлэлт;
- Хог хаягдал булах, устгах төвлөрсөн цэг, байгууламжийн хүчин чадал, тоноглол, техник технологи, ашиглалтын үзүүлэлт;
- Хог хаягдлаа ялган хаядаг үзүүлэлт;

2.4. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хог хаягдлын хүндийн жингийн нэгж хэмжээнд тооцож тогтооно. Хог хаягдлын овор хэмжээ, эзэлхүүнийг эх үүсвэр дээр нь бууруулах менежментийг хэрэгжүүлэх зорилгоор зарим төрлийн хог хаягдлын хураамжийг нэгж эзэлхүүнээр нь тооцож болно.

2.5. Ялгасан дахин ашиглах боломжтой хог хаягдал, дахиварын үйлчилгээний хураамжид хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж болно.

2.6. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ.<sup>3</sup> Аймаг, нийслэлийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зорилгоор суурь зардлаас бусад хэсгийг аймаг, нийслэлийн түвшинд төвлөрүүлэн ашиглаж болно.

### **Гурав. Хог хаягдлын үйчилгээний хураамжийг ялгавартай тогтооход итгэлцүүр үзүүлэлт ашиглах нь**

Хог хаягдлын үйчилгээний хураамжийг зөвхөн суурь зардал тооцох аргачлалаар тогтоож, итгэлцүүр ашиглах замаар нэмэлт зардалд шаардагдах санхүүжилтын эх үүсвэрийг бүрдүүлж болно. Итгэлцүүр ашиглан хог хаягдлын үйлчилгээний хураамжийг ялгавартай тогтоосон тохиолдолд уг аргачлалын 2.2.2-т заасан нэмэлт зардлыг үйчилгээний хураамжид оруулж тооцохгүй.

Дараахь итгэлцүүрүүдийг үйлчилгээний хураамжийг тооцоход ашиглана. Үүнд:

- $I_y$  –энгийн ялган ангилалтын
- $I_a$  –аюултай хаягдлын ялган ангилалтын
- $I_b$  –тайлан бүртгэлийн

Сүүлчийн хоёр итгэлцүүр (аюултай хаягдлын ялган ангилалтын, тайлан бүртгэлийн итгэлцүүр)-ийг хог хаягдлын улсын нэгдсэн тооллого, бүртгэлийн ажил зохион байгуулагдаж, анхан шатны

<sup>3</sup> Хог хаягдлын тухай хуулийн 20.2 заалт

засаг захиргааны нэгжид хог хаягдлын мэдээллийн сан суурилагдснаас хойш хоёр улирлын дараа ашиглана.

### 3.1. Энгийн ялган ангилалтын итгэлцүүр И<sub>я</sub>

Ахуйн хог хаягдлыг ялган хаядаг, хаядаггүйгээс хамаарч үйлчилгээний хураамжийг ялгавартай тогтоох зорилгоор хураамжид өөрчлөлт оруулах хувьсагч үзүүлэлт юм. Тухайн орон нутагт хог хаягдал ялган хаях тухай журам мөрдөгдөж эхэлснээс хойш ашиглагдана.

### 3.2. Хог хаягдлын тайлан бүртгэлийн итгэлцүүр

Хог хаягдал нь хүний үйл ажиллагааны бүхий л хэлбэрээс байнга тасралтгүй гарч байдаг ашиглагдахгүй болсон материалын урсгал бөгөөд түүний хэмжээ, бүрэлдэхүүнийг үнэн зөв тогтоох, бүртгэлжүүлэх нь их хэмжээний хөрөнгө, цаг хугацаа шаардсан ажил тул хог үүсгэгч бүрийн хичээл зүтгэл, оролцоог хангахад чиглэгдсэн итгэлцүүр юм. Хог хаягдлын улсын тоо бүртгэлд хамрагдахгүй байгаа, тайлан мэдээлэлээ гаргахгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлчилгээний хураамжид өөрчлөлт оруулах зорилготой хувьсагч үзүүлэлт.

### 3.3. Аюултай болон хатуу хаягдлын ялган ангилалтын итгэлцүүр

И<sub>а</sub> –итгэлцүүрийг аюултай хаягдлын ангилалд орсон хог хаягдал гаргадаг бүх төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа иргэн, хуулийн этгээдүүдийн хог хаягдлын хураамжийг тооцоход ашиглана.

### 3.4 . Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эх үүсвэрийн төрлөөс хамааруулж тооцох

Хүснэгт 1. Итгэлцүүрийн хог хаягдлын эх үүсвэртэй харгалзуулсан үзүүлэлт

<i>Ялгавартай тогтоох нөхцөл</i>	<i>Эх үүсвэрийн төрөл</i>					
	<i>Айл өрх / иргэн</i>	<i>Ахуйн үйлчилгээний байгууллага, ААН</i>	<i>Нийтийн хоол, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллага, ААН</i>	<i>Уул уурхай</i>	<i>Барилга</i>	<i>Эмнэлэг</i>
• Ия –энгийн ялган ангилалтын итгэлцүүр						
Хаягдлаа ангилаагүй	1.2	1.2	1.2	1.5	1.5	1.5
Хаягдлаа ангилсан	1	1	1	1	1	1
• Иа –аюултай хаягдлын ялган ангилалтын итгэлцүүр						
Аюултай хаягдлаа ялгаагүй	-	1.5	1.1	2.2	1.8	1.8
Аюултай хаягдлаа ялгасан	-	1	1	1	1	1
• Иб –тайлан бүртгэлийн						
Мэдээллийн санд бүртгэлгүй, тайлан гаргадаггүй	-	1.1	1.1	1.2	1.2	1.2
Мэдээллийн санд бүртгэлтэй, тайлан гаргадаг	-	1	1	1	1	1